



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/64/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2020 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: ariunaach@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК

Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	САЙНШАНД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ II СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.ЦЭРЭНЛХАМ ТАНАА
2020.02.28 № 1-6/216	
танай _____-ны № _____-т	
Аудитын гэрчилгээ	
<p>Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Сайншанд сумын ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Цэрэнлхам Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 2-ноос 2020 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 14-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Уваа уул аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь боловсролын үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бага боловсрол
- Суурь боловсрол
- Дунд боловсролд олгох.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ХАОАТ-ын тухай хууль
- Засгийн газрын 2019.01.09-ний өдрийн 05, 06, 07 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019.01.16-ны өдрийн 24, 25 дугаар тогтоол
- Засгийн гарзын 2019.04.03-ны өдрийн 126 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019.10.30-ны 395 дугаар тогтоол

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,976,329.9 мянган төгрөгөөс тооцон 19,763.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 19,763.3 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үеэс өөрчлөгдөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,590.9 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	9,026.1	838.8	(8,187.3)
Урьдчилгаа	4,000.0	-	(4,000.0)
Бараа материал	119,792.8	145,325.7	25,532.9
Үндсэн хөрөнгө	2,897,080.2	2,849,143.7	(47,936.5)
Нийт хөрөнгө	3,029,899.2	2,995,308.3	(34,590.9)
Өр төлбөр	-	246.0	246.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,029,899.2	2,995,062.3	(34,836.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,029,899.2	2,995,308.3	(34,590.9)

Авлага дансны үлдэгдэл буурсан нь жилийн эцсийн гүйлгээ 26-ны өдөр хаагддаг бөгөөд үдийн цайны зардал гүйцэтгэлээр гардаг бөгөөд гүйлгээ хаагдсанаас хойшхи тооцоолол болон гүйцэтгэлийн зөрүүнээс шалтгаалжээ. Өмнөх оны авлагыг бүрэн барагдуулсан бөгөөд авлага дансны үлдэгдэл нь 2019 онд үүссэн болно. Барагдах боломжгүй, эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 2019 оноос хэрэгжиж байгаа түрээсийн ном үйлчилгээтэй холбоотой бөгөөд 19,249.8 мянган төгрөгийн түрээсийн номыг Тусгай зориулалтын материал дансанд бүртгэснээс шалтгаалжээ. Бараа материалын дансанд ашиглагддаггүй материал байхгүй. Оны эцэст 600.0 мянган

төгрөгийн цэвэрлэгээний болон бичиг хэргийн материалын худалдан авалт хийсэн нь байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой.

Бараа материалын дансанд бусад байгууллагад хамааралтай материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь хуримтлагдсан элэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 44,994.2 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан мянган төгрөгийн 37,632.8 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

. Үндсэн хөрөнгө худалдан авсан 51,279.2 мянган төгрөгийн, хандиваар 12,310.8 мянган төгрөгийн болон шилжүүлэн авсан 21,919.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 46,808.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө буурсан нь хуримтлагдсан элэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь жилийн эцсийн гүйлгээ 26-ны өдөр хаагддаг бөгөөд үдийн цайны зардал гүйцэтгэлээр гардаг бөгөөд гүйлгээ хаагдсанаас хойшхи тооцоолол болон гүйцэтгэлийн зөрүүнээс шалтгаалжээ. Өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 246.0 мянган төгрөг нь 2019 онд үүссэн болно

Урт хугацаат өр төлбөр байхгүй. Өр төлбөр дансны үлдэгдэлд барьцаа хөрөнгө байхгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,999,725.1 мянган төгрөг болж, 36,699.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн -33,565.3 мянган төгрөг, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт -1,645.4 мянган төгрөг, Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт -1,488.2 мянган төгрөг гарснаас шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургууль нь тайлант онд 1,864,809.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,864,809.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100.0 хувиар биелүүлсэн байна. Төсөвт 14,514.5 мянган төгрөгийг эх үүсвэрээс буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зориулан 1,864,809.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,864,809.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,618,930.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 245,879.1 мөнгөн төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын гүйцэтгэл 1,313,131.5 мянган төгрөг буюу 100%, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн гүйцэтгэл 160,578.8 мянган төгрөг буюу 98,4%, энэ нь өмнөх онд НД-аас авлагатай байсантай холбоотой. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын гүйцэтгэл 222,654.3 мянган төгрөг буюу 95.1% байгаа нь цахилгааны хэмнэлтийг сургуулийн бүх гэрлийг шинэчилснээр үүсгэсэн. Бусад зардлуудын гүйцэтгэл 99.7% байна.. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,850,295.1 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цахилгааны зардлын хэмнэлттэй холбоотой

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 30,869.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Бага ангийн заах аргын нэгдлийн хэрэгжүүлж буй төсөлд 15,580 мянга, сургуулийн гадна хаалга солиход 2,882.5 мянган төгрөг, 3 үйлдэлт хэвлэх төхөөрөмжид 3,800.0 мянган төгрөг, сургуулийн багш нарын амралтын өрөөний тавилгад 1,930.0 мянга, сургуулийн багш нарын урлагийн үзлэгийн шагналд 600 мянга, бусад шаардлагатай материалд 1,366.7 мянга, нийт 26,159.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4,710.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж, нийт 19 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 189,970.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 189,970.3 мянган төгрөгийн алдааг залруулав.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарах асуудал байхгүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 117 мэдээллийг хугацаанд нь, 17 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,729.08 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,107.08 мянган төгрөгийн төлбөрийн акт, 5,622.0 мянган төгрөгийн зөвлөмж өгөгдсөн. Албан шаардлага өгөгдөөгүй. Акт, зөвлөмж бүрэн хэрэгжсэн.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй алдаа, зөрчил байхгүй учраас Зөрчилгүй дүгнэлт өглөө.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлдэг. Харин Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургууль нь аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг аудитын явцад залруулсан тул анхаарвал зохих асуудлуудыг жагсааж үзүүлэх шаардлагагүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	132,818,991.93	146,164,535.21
33	АВЛАГА	9,026,145.00	838,800.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	984,796.00	00.00
335	Бусад авлага	8,041,349.00	838,800.00
3351	Байгууллагаас авах авлага	8,041,349.00	838,800.00
34	УРЬДЧИЛГАА	4,000,000.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	4,000,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	119,792,846.93	145,325,735.21
351	Түүхий эд материал	9,908,740.00	29,203,588.50
35110	Тусгай зориулалттай материал	9,908,740.00	29,203,588.50
354	Хангамжийн материал	109,884,106.93	116,122,146.71
35410	Бичиг хэргийн материал	807,730.00	1,383,890.00
35420	Аж ахуйн материал	13,608,253.41	12,093,608.19
35440	Түлш, шатах тослох материал	543,000.00	951,000.00
35470	Бусад хангамжийн материал	94,925,123.52	101,693,648.52
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,897,080,185.04	2,849,143,727.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,897,080,185.04	2,849,143,727.55
392	Биет хөрөнгө	2,561,036,709.57	2,513,143,727.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,280,634,166.66	2,283,516,738.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-63,825,549.49
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	422,720,360.24	427,170,140.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-290,679,440.54	-306,279,540.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	171,466,720.13	171,321,209.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	-99,600,688.67	-105,831,927.99
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,635,631.47	15,635,631.47
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-936,864.00
39217	Ном	60,859,960.28	92,373,889.09
393	Биет бус хөрөнгө	336,043,475.47	336,000,000.00
39301	Програм хангамж	1,332,227.50	1,332,227.50
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,288,752.03	-1,332,227.50
39303	Бусад биет бус хөрөнгө	336,400,000.00	336,400,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.00	-400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,029,899,176.97	2,995,308,262.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	246,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	246,000.00
413	Өглөг	00.00	246,000.00
4136	Бусад өглөг	00.00	246,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	246,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,029,899,176.97	2,995,062,262.76
51	Засгийн газрын хувь оролцоо	3,029,899,176.97	2,995,062,262.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,834,541,954.01	1,834,541,954.01
51101	Өмч: - төрийн	1,834,541,954.01	1,834,541,954.01
512	Хуримтлагдсан үр дүн	-178,391,991.08	-211,740,696.94
51210	Өмнөх үеийн үр дүн	-178,391,991.08	-178,176,293.60
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-33,564,403.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,373,749,214.04	1,372,261,005.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,029,899,176.97	2,995,308,262.76

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,575,854,795.72	1,942,764,577.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,172,445.72	54,623,522.15
120	Нийтлэг татварын бус орлого	46,172,445.72	54,623,522.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,172,445.72	54,623,522.15
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	46,172,445.72	54,623,522.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	21,628,250.00	269,210,555.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,508,054,100.00	1,618,930,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,628,250.00	23,331,455.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,278,560.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,349,690.00	23,331,455.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	245,879,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	245,879,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,526,830,766.95	1,974,586,730.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,526,830,766.95	1,974,586,730.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,431,538,666.45	1,874,672,525.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	978,876,273.00	1,313,219,446.94
210101	Үндсэн цалин	807,814,287.00	1,016,440,665.94
210102	Нэмэгдэл	143,026,895.00	296,778,781.00
210104	Урамшуулал	28,035,091.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,861,999.00	161,455,820.83
210201	Тэтгэврийн даатгал	107,330,599.00	112,014,329.90
210202	Тэтгэмжийн даатгал	2,382,900.00	13,055,610.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,906,100.00	10,019,596.01
210204	Ажилгүйдлийн даатгал	476,600.00	2,405,784.49
210205	Эрүүл мэндийн даатгал	4,765,800.00	23,960,499.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,606,352.00	222,776,592.48
210301	Гэрэл, цахилгаан	3,885,639.00	10,364,822.48
210302	Түлш, халаалт	163,822,120.00	197,076,582.00
210303	Цэвэр, бохир ус	14,898,593.00	15,335,188.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,474,396.26	13,414,729.80
210401	Бичиг хэрэг	4,164,377.86	3,580,760.00
210402	Тээвэр, шатахуун	1,233,250.00	1,109,460.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,982,798.00	2,378,839.00
210404	Ном, хэвлэл	3,141,283.40	44,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	282,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,670,687.00	2,487,671.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	3,573,499.80
2105	Нормативт зардал	1,303,772.63	1,166,400.00
210502	Хоол, хүнс	245,389.00	450,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,058,383.63	716,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,183,978.51	18,077,512.83
210604	Урсгал засвар	13,183,978.51	18,077,512.83
2107	Томилолт, зочны зардал	1,298,300.00	5,116,800.00
210702	Дотоод албан томилолт	1,298,300.00	5,116,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,857,500.00	2,829,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,857,500.00	2,829,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,076,095.05	136,615,722.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,828,318.50	4,219,506.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,784,720.01	1,486,136.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	113,463,056.54	130,910,080.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	95,292,100.50	99,914,204.52
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,630,300.50	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,630,300.50	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,661,800.00	85,399,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	72,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	77,187,600.00	84,478,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,402,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	920,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,039,708.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,039,708.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	11,474,796.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	11,474,796.52
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	49,024,028.77	-31,822,152.99
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,907,008.71	1,742,026.51
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	482,000.00	1,742,026.51
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	2,425,008.71	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,907,008.71	-1,742,026.51
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	46,117,020.06	-33,564,179.50

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,529,682,350.00	1,896,059,331.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,529,682,350.00	1,896,059,331.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,508,054,100.00	1,618,930,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,628,250.00	31,249,731.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,278,560.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,349,690.00	31,249,731.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	245,879,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	245,879,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,423,805,764.00	1,848,182,534.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,423,805,764.00	1,848,182,534.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,320,197,197.50	1,747,397,329.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	980,527,879.00	1,313,131,500.00
210101	Үндсэн цалин	639,695,796.00	736,347,100.00
210102	Нэмэгдэл	282,739,591.00	488,016,231.00
210104	Урамшуулал	58,092,492.00	88,768,169.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,366,227.00	160,578,822.00
210201	Тэтгэврийн даатгал	118,366,227.00	110,886,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	10,650,101.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	12,962,863.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,873,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	24,206,558.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	180,750,092.00	222,654,309.48
210301	Гэрэл, цахилгаан	3,885,639.00	10,908,376.48
210302	Түлш, халаалт	162,681,866.00	197,076,582.00
210303	Цэвэр, бохир ус	14,182,587.00	14,669,351.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,563,898.00	9,141,772.00
210401	Бичиг хэрэг	1,119,370.00	2,187,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,102,000.00	1,517,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,797,798.00	2,023,839.00
210404	Ном, хэвлэл	93,000.00	762,725.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	282,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,169,730.00	2,409,848.00
2105	Нормативт зардал	1,789,500.00	1,800,000.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,789,500.00	1,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,458,287.50	14,901,990.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,070,300.00	2,991,996.00
210602	Тавилга	00.00	560,000.00
210604	Урсгал засвар	7,387,987.50	11,349,994.00
2107	Томилолт, зочны зардал	1,298,300.00	5,066,800.00
210702	Дотоод албан томилолт	1,298,300.00	5,066,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,895,500.00	2,378,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,895,500.00	2,378,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,547,514.00	17,744,136.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,645,149.00	7,117,636.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,902,365.00	10,626,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,608,566.50	100,785,204.52
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	12,548,566.50	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	12,548,566.50	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,060,000.00	86,270,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	80,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	77,577,800.00	85,070,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,402,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,199,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,039,708.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,039,708.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	11,474,796.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	11,474,796.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>105,876,586.00</u>	<u>47,876,797.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	105,876,586.00	47,876,797.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	105,876,586.00	47,876,797.00
2200	Дотоод эх үүсвэрээр	105,876,586.00	47,876,797.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	105,876,586.00	47,876,797.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-105,876,586.00</u>	<u>-47,876,797.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,834,541,954.01	1,373,749,214.04	-178,391,991.09	3,029,899,176.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	215,697.48	215,697.48
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,834,541,954.01	1,373,749,214.04	-178,176,293.61	3,030,114,874.44
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,488,208.35		-1,488,208.35
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-33,564,179.50	-33,564,179.50
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,834,541,954.01	1,372,261,005.69	-211,740,473.11	2,995,062,486.59

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,864,809,600.00	1,850,295,123.48	14,514,476.52	99.2
УРСГАЛ ЗАРДАЛ	1,864,809,600.00	1,850,295,123.48	14,514,476.52	99.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,778,250,000.00	1,764,024,423.48	14,225,576.52	99.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,313,131,500.00	1,313,131,500.00	-	100.0
Үндсэн цалин	735,547,100.00	736,347,100.00	(800,000.00)	100.1
Нэмэгдэл	497,136,100.00	488,016,231.00	9,119,869.00	98.1
Урамшуулал	80,448,300.00	88,768,169.00	(8,319,869.00)	110.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	163,204,000.00	160,578,822.00	2,625,178.00	98.3
Тэтгэврийн даатгал	112,590,600.00	110,886,100.00	1,704,500.00	98.4
Тэтгэмжийн даатгал	10,122,600.00	10,650,101.00	(527,501.00)	105.2
ҮОМШӨ-ний даатгал	12,653,400.00	12,962,863.00	(309,463.00)	102.4
Ажилгүйдлийн даатгал	2,530,600.00	1,873,200.00	657,400.00	74.0
Эрүүл мэндийн даатгал	25,306,800.00	24,206,558.00	1,100,242.00	95.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	234,129,100.00	222,654,309.48	11,474,790.52	95.1
Гэрэл, цахилгаан	18,750,000.00	10,908,376.48	7,841,623.52	58.1
Түлш, халаалт	193,009,500.00	197,076,582.00	(4,067,082.00)	102.1
Цэвэр, бохир ус	22,369,600.00	14,669,351.00	7,700,249.00	65.5
Хангамж, бараа материалын зардал	7,943,600.00	7,943,207.00	393.00	100.0
Бичиг хэрэг	1,161,600.00	1,617,900.00	(456,300.00)	139.2
Тээвэр, шатахуун	700,000.00	1,317,470.00	(617,470.00)	188.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,800,000.00	2,023,839.00	776,161.00	72.2
Ном, хэвлэл	500,000.00	334,150.00	165,850.00	66.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	282,000.00	240,000.00	42,000.00	85.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	2,409,848.00	90,152.00	96.3
Нормативт зардал	1,800,000.00	1,800,000.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	1,800,000.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	30,829,400.00	30,739,394.00	90,006.00	99.7

Багаж, техник, хэрэгсэл	9,900,000.00	9,900,000.00	-	100.0
Тавилга	9,179,400.00	9,089,400.00	90,000.00	99.0
Урсгал засвар	11,750,000.00	11,749,994.00	6.00	100.0
Томилолт, зочны зардал	5,100,000.00	5,066,800.00	33,200.00	99.3
Дотоод албан томилолт	5,100,000.00	5,066,800.00	33,200.00	99.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,200,000.00	2,198,000.00	2,000.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,200,000.00	2,198,000.00	2,000.00	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	19912400.00	19912391.00	9.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,900,000.00	1,899,991.00	9.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,012,400.00	18,012,400.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86559600.00	86270700.00	288,900.00	99.6
Бусад урсгал шилжүүлэг	86,559,600.00	86,270,700.00	288,900.00	99.6
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	85,359,600.00	85,070,800.00	288,800.00	99.6
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,199,900.00	100.00	99.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,864,809,600.00	1,850,295,123.48	14,514,476.52	99.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,618,930,500.00	1,615,890,820.00	3,039,680.00	99.8
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,618,930,500.00	1,615,890,820.00	3,039,680.00	99.8
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	245,879,100.00	234,404,303.48	11,474,796.52	95.3
Орон нутгийн төсвөөс	245,879,100.00	234,404,303.48	11,474,796.52	95.3

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		31,249,703.00
УРСГАЛ ЗАРДАЛ		31,249,703.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		31,249,703.00
Хангамж, бараа материалын зардал		3,469,990.00
Бичиг хэрэг		570,000.00
Тээвэр, шатахуун		199,990.00
Ном, хэвлэл		2,700,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		9,399,596.00
Багаж, техник, хэрэгсэл		5,831,996.00
Тавилга		3,567,600.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		180,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		180,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		18,200,117.00
Бараа үйлчилгээний бусад зардал		15,010,117.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		3,190,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		31,249,721.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		31,249,721.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		31,249,721.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Сайншанд сумын ЕБС-2-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.12.31			ДГА-2020/64/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Сайншанд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд бичсэн.	4,415.8	Залруулах	Захирал нябо	Д.Цэрэнлхам Б.Уянга
2	Цалингийн өглөг дансны ДТ-ээс цалингийн урьдчилгаа болон утасны төлбөрийн суутгалын бичилтийг хийхдээ Цалингийн урьдчилгаа болон Байгууллагад өгөх өглөг дансуудын хааж бус харин Мөнгөн хөрөнгийн КТ-д бичиж дансны бичилтийг буруу хийсэн.	161,260.8	Залруулах	Захирал нябо	Д.Цэрэнлхам Б.Уянга
3	Хөдөлмөрийн чадвараа түр алдсан болон жирэмсэн эхийн тэтгэмжийн мөнгийг нийгмийн даатгалын газраас авахаар тооцсон үед орлого, мөнгөн хөрөнгө дансыг харьцуулж, дансны бичилт буруу хийсэн.	24,293.7	Залруулах	Захирал нябо	Д.Цэрэнлхам Б.Уянга